




БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 V



<https://bayankhongor.nso.mn/>



Баянхонгор аймаг
2024 он

НЭГ. АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР	2
БҮЛЭГ I НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ	4
I Нийгмийн халамж	4
II. Нийгмийн даатгал	5
III. Эрүүл мэнд	5
IV БОЛОВСРОЛ	6
v. Гэмт хэргийн нөхцөл байдал	8
БҮЛЭГ II ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	9
VI. Орон нутгийн төсвийн орлого, зарлага	9
VII. Мөнгө, зээл, хадгаламж	10
VIII Дотоодын нийт бүтээгдэхүүн	11
IX. Хэрэглээний үнэ	12
X. Хөдөө аж ахуй	12
XI. Аж үйлдвэр	13

НЭГ. АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

- Нийгмийн халамж: Монгол Улсын хуулиар олгож буй тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж байгаа хүний тоо болон мөнгөн дүнгээр оруулсан./ХХҮГ/
- Нийгмийн даатгал: Монгол Улсын хуулиар олгож буй тэтгэвэр тэтгэмжид хамрагдаж байгаа хүний тоо болон мөнгөн дүнгээр оруулсан./НДХ/
- Эрүүл мэнд: Уг салбарын мэдээнүүдийг холбогдох газар, хэлтсүүд нь нэгтгэн гаргаж ирүүлдэг.
 - 1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
 - 1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
- Гэмт хэрэг: Аймгийн цагдаагийн газраас захиргааны статистик мэдээгээр нэгтгэн гаргадаг.
- Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл өөрчлөгдсөн.

 - Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.
 - Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.
 - Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдыг эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.
 - Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.
 - Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.
 - 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог оны эхний 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.
- Мөнгө, банк: Монгол банк арилжааны банкнудаас мэдээг авч нэгтгэн, банкнуудын үндсэн материалын хамт ирүүлдэг.
- Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ. Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.
- Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.
- Хөдөө аж ахуй: Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар өрхөөс цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.
- Аж үйлдвэр: Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үндсэн нэгжүүд мэдээг ирүүлдэг.

Борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд оны үнээр үнэлж, худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

БҮЛЭГ I НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

I. НИЙГМИЙН ХАЛАМЖ



Нийгмийн халамжийн сангаас 2024 оны 5 сард нийт 66541 хүнд 26,788.2 сая төгрөгийн олголт хийж, үүнээс халамжийн тэтгэвэр 1877 хүнд 3,197.3 сая төгрөг, халамжийн тэтгэмж 1975 хүнд 2,688.4 сая төгрөг, амьжиргаа дэмжих мөнгөн тусламж 1921 хүнд 635.5 сая төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 1085 эхчүүдэд 120.3 сая төгрөг, алдарт эхийн одонгийн тусламж 8136 эхэд 1,027.0 сая төгрөг, алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 2 хүнд 0.5 сая төгрөг, насны хишиг 4161 хүнд 343.7 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд 4193 ээжид 929.8 сая төгрөг, өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн хүрээнд 272 хүнд 178.5 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж 7 хүнд 21.0 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 34641 хүүхдэд 17,111.8 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг тусламжаар үзүүлэх үйлчилгээ 5229 хүнд 322.0 сая төгрөг, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж 2642 хүнд 149.3 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусламж, хөнгөлөлт 253 хүнд 53.0 сая төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал 147 хүнд 9.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 17 хүнд 20.4 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Ажилгүйдэл, Ажлын байр, Ажиллагсад

2024 оны 5 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 137 байгаагаас, нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 76 буюу 55.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 72.6 хувь буюу 77 иргэн, 45 дээш насныхан 29 иргэн 27.3 хувийг эзэлж байна. Харин боловсролын түвшинээр нь харвал боловсролгүй 3 иргэн үүнээс эмэгтэй 2, бага боловсролтой 5 иргэн үүнээс 1 эмэгтэй, суурь боловсролтой 6 иргэн үүнээс 3 эмэгтэй, бүрэн дунд хүртэл боловсролтой 48 иргэн үүнээс 30 эмэгтэй, техникийн болон мэргэжлийн боловсролтой 15 иргэн үүнээс 6 эмэгтэй, тусгай мэргэжлийн боловсролтой 2 иргэн үүнээс 1 эмэгтэй, дипломын дээд боловсролтой 9 иргэн үүнээс 6 эмэгтэй, бакалаврын боловсролтой 18 иргэн үүнээс 8 эмэгтэй, магистр, докторын боловсролтой 3 иргэн үүнээс 2 эмэгтэй байна, хувиар харвал боловсролгүй иргэн 2.8 хувь, бага боловсролтой 4.7 хувь, суурь боловсролтой 5.7 хувь, бүрэн дунд хүртэл боловсролтой 45.3 хувь, техникийн болон мэргэжлийн боловсролтой 14.2 хувь, тусгай мэргэжлийн боловсролтой 1.9 хувь, дипломын дээд боловсролтой 8.5 хувь, бакалаврын боловсролтой 14.2 хувь, магистр, доктор боловсролтой иргэд 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Улирлын шинэ ажлын байранд нийт 2 иргэн ажилд орсон бөгөөд 35-44 насны 1 эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Улирлын шинэ ажлын байранд ажиллаж байгаа иргэдийг эдийн засгийн салбараар харвал боловсролын салбарт 1, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт 1 хүнд улирлын шинэ ажлын байр гаргаж ажиллаж байна.

2024 оны 05 сарын байдлаар 141 ажлын байрны захиалга ирсэн байна. Ажлын байрны захиалгыг ажил мэргэжлийн ангиллаар харвал Менежер 6, Мэргэжилтэн 30, Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн 5, Контор, үйлчилгээний ажилтан 13, Худалдаа, үйлчилгээний ажилтан 30, Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан 0, Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил 3, Суурин төхөөрөмж, машин механизмын

операторч, угсрагч 2, Зэвсэгт хүчний ажил, мэргэжил тус тус 0, Энгийн ажил, мэргэжил салбарт 52 ажлын байрны захиалга тус тус иржээ.

Эхний 5 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдээс 119 хүн ажилд зуучлагдан орсон ба 69 иргэн буюу 58 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд орсон иргэдийн 65.5 хувь нь 15-44 насныхан байжээ. Ажилд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур 23, Уул уурхай олборлолт 6, Боловсруулах үйлдвэр 19, Цахилгаан, хий, уур агааржуулалт 0, Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт 28, барилга 2, Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклийн засвар үйлчилгээ 10, Тээвэр ба агуулахын үйлчилгээ 0, Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 3, мэдээлэл холбоо, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа тус тус 0, Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 12, боловсрол 10, Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 1, Урлаг, үзвэр, тоглоом наадам 0, Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 5, Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллангаа, Олон улсын байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбарт 0 зуучлагдан ажилд оржээ.

Эх үүсвэр: аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар

II. НИЙГМИЙН ДААТГАЛ



2024 оны эхний 5 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэрт 36,754.2 сая төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт 3,644.4 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 1,264.6 сая төгрөг, цэргийн тэтгэвэрт 754.9 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 6.2 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжид 1,523.8 сая төгрөг, оршуулгын тэтгэмжид 312.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 36.8 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 35.6 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжид 384.8 сая төгрөг тус тус олгожээ.

Эх үүсвэр: Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

III. ЭРҮҮЛ МЭНД



Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 5 сарын байдлаар нийт 597 эх төрж, өнгөрсөн оны мөн үеэс 78 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 94.8 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 5.2 хувь нь сумын эмнэлэгт төрсөн.

Эхний 5 сард аймгийн хэмжээнд нийт 695 халдварт өвчин бүртгэгдэж 10.000 хүн амд 78.7 хувь байгааг 2023 оны мөн үетэй (54.3) харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна. БЗДХ-ын тохиолдлын тоо урьд оны мөн үеэс өсч, нийт халдварт өвчний 34.8 хувийг эзэлж байна. Бүртгэгдсэн БЗДХ-ын 242 тохиолдлын 26.0 хувийг заг хүйтэн, 45.9 хувийг трихомониаз, 28.1 хувийг тэмбүүгийн өвчлөл тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт нас баралтын 175 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оноос 18 тохиолдлоор буурч, нийт нас баралтын 21.7 хувь нь эмнэлэгт нас барснаас 36.8 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеээс (хоноггүй 2023 онд 34.2

хувь) нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд хорт хавдрын 39, осол гэмтлийн 25 нас баралт бүртгэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хорт хавдрын шалтгаант нас баралт, осол гэмтлийн шалтгаант нас баралт тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Эхний 5 сард нийт 5965 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 23.0 хувийг алсын, 7.3 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн нийт дуудлагын тоо, нийт дуудлагад эзлэх алсын болон осол гэмтлийн дуудлагын хувь буурсан үзүүлэлттэй байна.

Эх үүсвэр: аймгийн Эрүүл мэндийн газар

IV.ХҮН АМ



Аймгийн суурин хүн амын тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 88499 болж, өмнөх оноос 1144 хүнээр буюу 0.1 хувиар буурсан байна. Хүн амын 2.7 хувь нь Баянхонгор аймагт амьдарч байна. Үүнээс хүйсээр авч үзэхэд 49.4 хувь эрэгтэй, 50.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН ТОО, 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР /Сумаар/

Сум	Бүгд			Нийслэл			Тосгон		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Баацагаан	3062	1590	1472						
Баянбулаг	1724	851	873						
Баянговь	3021	1478	1543						
Баянлиг	3714	1848	1866						
Баян-Овоо	2449	1324	1125						
Баян-Өндөр	2504	1286	1218						
Баянхонгор	32835	15499	17336	31424	14794	16630	1411	705	706
Баянцагаан	3449	1736	1713						
Богд	2986	1459	1527						
Бөмбөгөр	3306	1679	1627						
Бууцагаан	3621	1830	1791						
Галуут	4179	2200	1979						
Гурванбулаг	2227	1129	1098						
Жаргалант	2835	1406	1429						
Жинст	2140	1073	1067						
Заг	2073	1038	1035						
Өлзийт	3815	1921	1894						
Хүрээмарал	1679	839	840						
Шинэжинст	2565	1283	1282						
Эрдэнэцогт	4315	2211	2104						
	88499	43680	44819	31424	14794	16630	1411	705	706

ХҮСНЭГТ 2. ОРШИН СУУГАА ИРГЭД, 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР

Сум	Сумын төв			Хөдөө		
	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм
Баацагаан	301	140	161	2761	1450	1311
Баянбулаг	304	150	154	1420	701	719
Баянговь	581	271	310	2440	1207	1233
Баянлиг	912	461	451	2802	1387	1415
Баян-Овоо	551	292	259	1898	1032	866
Баян-Өндөр	467	243	224	2037	1043	994
Баянхонгор	0	0	0	0	0	0

Баянцагаан	473	222	251	2976	1514	1462
Богд	521	246	275	2465	1213	1252
Бөмбөгөр	740	346	394	2566	1333	1233
Бууцагаан	460	223	237	3161	1607	1554
Галуут	605	311	294	3574	1889	1685
Гурванбулаг	224	112	112	2003	1017	986
Жаргалант	527	248	279	2308	1158	1150
Жинст	406	207	199	1734	866	868
Заг	562	285	277	1511	753	758
Өлзийт	681	329	352	3134	1592	1542
Хүрээмарал	211	104	107	1468	735	733
Шинэжинст	283	139	144	2282	1144	1138
Эрдэнэцогт	837	422	415	3478	1789	1689
	9646	4751	4895	46018	23430	22588

V. БОЛОВСРОЛ



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд 19162 суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 444 (2.3%) хүүхдээр өсжээ.


Нийт суралцагчдын 9563 (48.9%) нь 1-5-р ангид, 6936 (35.4%) нь 6-9-р ангид, 2083 (15.7%) нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1901 суралцагчид элсэн орсны 967 (50.9%) эмэгтэй суралцагчид байна. Мөн 12-р ангид 856 суралцагчид байгаагийн 452 (52.8%) нь эмэгтэй суралцагчид байна.


Энэ хичээлийн жилд 691 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 27 суралцагч ногдож байна. Нэг багшид ногдох суралцагчийн тоо 20 байна.

Нийт ажиллагсдын 1016 (55%) үндсэн багш байна. Үндсэн багшийн 820 (80.7%) нь эмэгтэй багш нар байна. Дотуур байранд 1859 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 50 (2.6%) сурагчаар өсжээ.

ЗУРАГ 1. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ӨДРӨӨР СУРАЛЦАГЧИД, жил бүрийн хичээлийн жилд



ЗУРАГ.2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ жил бүрийн хичээлийн жилд




СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ


2023-2024 оны хичээлийн жилд 216 бүлэгт 7513 хүүхэд хүмүүжиж байна. Өмнөх оны мөн үеэс 1568 (27.1%) мянган хүүхдээр өсжээ.

42 сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 7513 хүүхдэд 259 багш, нийт 914 ажилчин боловсролын үйлчилгээ үзүүлж байна.

ЗУРАГ 3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО, жил бүрийн хичээлийн жилд



ЗУРАГ 4. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БАГШ, жил бүрийн хичээлийн жилд



Эх үүсвэр: аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газар

VI. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Тус цагдаагийн газар нь 2024 оны 5 сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1985 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 184 нэгжээр буюу 10.2 хувиар өссөн. Үүнээс 683 буюу 34.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1302 буюу 65.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 75 буюу 10.9 хувийг 5 хоногт, 515 буюу 75.4 хувийг 6-19 хоногт, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1243 буюу 95.4 хувийг 5 хоногт тус тус шалгаж шийдвэрлэжээ. Хүлээн авч шалгасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 83 буюу 12.1 хувийг, зөрчлийн шинжтэй 36 буюу 2.7 хувийг тус тус шийдвэрлээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг:

Аймгийн хэмжээнд энэ хугацаанд 326 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 164 буюу 1 дахин өссөн.


Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 232 хэрэг бүртгэгдсэнээс 49 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 21.1 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.2 пунктээр буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 223 буюу 68.4 хувь нь Баянхонгор суманд, 103 буюу 31.6 хувь нь бусад сумдад үйлдэгдсэн байна.


Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

Бүртгэгдсэн гэмт хэргийн 278 буюу 85.2 хувь нь хөнгөн ангиллын, 48 буюу 14.7 хувь нь хүнд ангиллын гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


ЗУРАГ.5. Гэмт хэргийн гаралтыг багаар нь:



ЗУРАГ.6. Үйлдэгдсэн гараг:



ЗУРАГ.7. Үйлдэгдсэн цаг



Гэмт хэргийн улмаас хохирсон хүн, байгууллага:

Гэмт хэргийн улмаас 296 иргэн хохирч, үүнээс 101 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 34 нэгжээр буюу 50.7 хувиар, 13 хүн нас барсан нь 9 нэгжээр буюу 2.2 дахин тус тус өссөн.

Гэмт хэргийн улмаас 1228.4 сая төгрөгийн хохирол учирснаас 307.9 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 25 хувьтай байна.

ХҮСНЭГТ 3. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ БАРАГДУУЛАЛТ

Он сар	Хохирол	Нөхөн төлүүлэлт	Битүүмжилсэн хөрөнгө
2023.05	614.9	109.6	7.2
2024.05	1218.4	307.9	85.6

Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Энэ хугацаанд нийт 158 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60 нэгжээр буюу 61.2 хувиар өссөн бөгөөд 42 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан 30 нэгжээр буюу 2.5 дахин өссөн байна.

Зөрчлийн мэдээ

Аймгийн хэмжээнд 2024 оны 5 сард нийт 14484 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 583 буюу 4.1 хувиар өсөж, үүнээс 14417 зөрчил буюу 99.5 хувийг нь шийдвэрлэсэн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 11454 буюу 79 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 750 буюу 5.1 хувийг Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 120 буюу 0.8 хувийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2160 буюу 14.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 13946 иргэнд 419995.5 сая төгрөгөөр торгох, 227 хүнийг баривчлах, 143 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 99 хүнийг баривчлуулж, эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Эх үүсвэр: аймгийн Цагдаагийн газар

БҮЛЭГ II ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

VII. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА



2024 оны 5 сарын байдлаар аймгийн төсвийн орлогын дүн 15,839.3 сая төгрөг болсон байна. 2024 оны 5 сарын нийт орлогын болон татварын орлогын төлөвлөгөөг Баянхонгор, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Гурванбулаг, Жаргалант, Өлзийт, Бөмбөгөр, Хүрээмарал, Баянбулаг, Заг, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст, Баацагаан, Бууцагаан сумууд давуулан биелүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг төрөл дээр нь авч үзвэл: НӨАТатвар 329.5 сая төгрөг, агаарын бохирдол /авто/ 5.7 сая төгрөг, ус бохирдуулсны төлбөр 6.8 сая төгрөг, ЦХХТА орлого /суутган-1/ 383.2 сая төгрөг, газрын төлбөр 38.1 сая төгрөг, агнуурын нөөц ашигласны төлбөр 181.6 сая төгрөг, хог хаягдлын хураамж 111.0 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 74.6 сая төгрөг, хүү торгуулийн орлого 87.2 сая төгрөг, ҮХЭХ борлуулсны орлого 53.2 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 74.3 сая төгрөгөөр тус

тус тасарч, орон нутгийн автозам ашигласны хураамж 16.8 сая төгрөг, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 31.1 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөр 74.3 сая төгрөг, ҮХЭХ-ийн татвар 4.8 сая төгрөг, малын тоо толгойн татвар 79.6 сая төгрөгөөр тус тус давуулан биелжээ.

Нийт орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар 7.4 хувь, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар 2.3 хувь, хүү торгууль 5.5 хувь. ЦХХТА орлого (суутган) 40.8 хувь, ААНОАТ (60%) 4.3 хувь, бусад төлбөр хураамж 39.7 хувийг тус тус эзэлж байна.

Эх үүсвэр: аймгийн Татварын хэлтэс

VIII. МӨНГӨ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ



Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2024 оны 5 дугаар сарын 31-ны байдлаар арилжааны банкнуудын нийт зээлийн үлдэгдэл 343,549.3 сая төгрөг байгаагийн 5,126.7 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 5,951.3 сая төгрөг нь чанаргүй зээл байна.

2024 оны 5 сард нийт хадгаламжийн үлдэгдэл 153,899.4 сая төгрөг байна. Үүний 26,830.9 сая төгрөг нь хугацаагүй хадгаламж, 127,068.4 сая төгрөг нь хугацаатай хадгаламж байна.

ХҮСНЭГТ 4.

	Үзүүлэлт	Үлдэгдэл
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	343,549,337.9
	Үүнээс: Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	5,126,775.0
	Чанаргүй зээлийн үлдэгдэл	5,951,267.4
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	57,104,841.0
	Үүнээс: Иргэдийн харилцахын үлдэгдэл	39,218,181.2
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	153,899,361.4
	Үүнээс: Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	153,851,267.3
	Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	26,830,933.0
	Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	127,068,428.5
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	54
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	229
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	59715
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	173164
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	66518
	Нийт АТМ-ны тоо	46
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	68425

IX. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН



Аймгийн ДНБ (оны үнээр) 2022 онд 537.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 53.6 хувиар өслөө. Аймгийн ДНБ улсын дүнд 1.0 хувийг эзэлж байна.

Аймгийн ДНБ-ийг томсгосон 3 салбар буюу хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбараар харьцуулан авч үзвэл, 2022 онд ДНБ-ий 263.6 (49.1%) тэрбум төгрөгийг хөдөө аж ахуйн салбар, 74.6 (13.9%) тэрбум төгрөгийг үйлдвэрлэлийн салбар, 199.2 (37.1%) тэрбум төгрөгийг

үйлчилгээний салбар бүрдүүлжээ.


Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотой өмнөх оноос хөдөө аж ахуйн салбар 2.0 дахин, үйлдвэрлэлийн салбар 61.3 хувиар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. ДНБ, салбараар

	ДНБ				НӨ-ийн жилийн цэвэр өөрчлөлт			
		Хөдөө аж ахуй	Үйлдвэрлэл	Үйлчилгээ	ДНБ	Хөдөө аж ахуй	Үйлдвэрлэл	Үйлчилгээ
		тэрбум төгрөг			хувь			
2019	454.0	232.3	74.2	147.4	22.2	20.9	40.3	16.7
2020	572.6	301.9	115.4	155.3	26.1	29.9	55.5	5.3
2021	350.0	131.0	46.2	172.8	-38.9	-56.6	-59.9	11.3
2022	537.4	263.6	74.6	199.2	53.6	2.0*	61.3	15.3

*- дахин их


ЗУРАГ 8. АЙМГИЙН ДНБ-ИЙ БҮТЭЦ, салбараар, дүнд эзлэх хувь



ДНБ-ий 2022 оны салбарын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, 2021 онд хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа буурсантай холбоотой хөдөө аж ахуйн салбарын оролцоо 11.7 нэгж хувиар нэмэгдэж,

үйлчилгээний салбарын оролцоо 12.3 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 9. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, сая төгрөг



Нэг хүнд ногдох ДНБ аймгийн дүнгээр 2020 онд 6.5 сая төгрөг байсан бол хөдөө аж ахуйн салбарын бууралттай холбоотой 2021 онд 3.9 сая төгрөг хүртэл буурч, харин 2022 онд 6.0 сая төгрөгт хүрсэн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм.

Эх үүсвэр: ҮСХ, Бүс нутгийн ДНБ-ий гүйцэтгэл

Х.ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ



Аймгийн өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс 2024 оны 5 сарын байдлаар өмнөх сартай харьцуулснаар 1.0 хувиар өсчээ. Ийнхүү өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн барааны үнэ, хувцас, бөс бараа, гутал бүлэг бараа бүтээгдэхүүний үнэ, эм тариа эмнэлгийн үйлчилгээ бүтээгдэхүүний үнэ, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ, бусад бараа үйлчилгээний үнэ, бусад бараа үйлчилгээний үнэ тус тус өссөн нь нөлөөлжээ.

Харин өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс 5 дугаар сарын байдлаар өмнөх оны жилийн эцэстэй харьцуулснаар 6.3 хувиар өсчээ, ийнхүү өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн барааны үнэ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад бүтээгдэхүүн, эм тариа эмнэлгийн үйлчилгээ бүтээгдэхүүний үнэ, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүтээгдэхүүн, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн бараа бүтээгдэхүүний үнэ, бусад бараа үйлчилгээний бүтээгдэхүүний үнэ тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.2 хувиар өссөн нь хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн барааны үнэ, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүтээгдэхүүний үнэ, хувцас, бөс бараа, гутал бүлэг, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад бүтээгдэхүүний үнэ, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүтээгдэхүүн, эм тариа эмнэлгийн үйлчилгээ барааны үнэ, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүтээгдэхүүн, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний үнэ, боловсролын үйлчилгээний үнэ, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ, бусад бараа бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор өссөн нь харагдаж байна.

ХҮСНЭГТ 6 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс

№	Барааны бүлгээр	2024.05/ 2023.05	2024.05/ 2023.12.	2024.05/ 2024.04
	Ерөнхий индекс	107.2	106.3	101.0
1	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	110.8	114.8	102.5
2	Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	100.4	98.2	99.5
3	Хувцас, бөс бараа, гутал	102.0	99.6	100.2
4	Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад	105.1	103.5	100.0
5	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.8	98.9	100.1
6	Эм тариа эмнэлгийн үйлчилгээ	104.0	100.5	100.6
7	Тээвэр	99.5	98.3	99.6
8	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	105.3	104.2	100.0
9	Амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	107.9	99.6	100.7
10	Боловсролын үйлчилгээ	110.6	100.0	100.0
11	Зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	115.8	115.8	101.4
12	Бусад бараа үйлчилгээ	120.8	115.4	101.2

ХҮСНЭГТ 7. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны үнэ, сараар

Нэр төрөл	2023.05	2024.05	2024.05
			2023.05
1-р зэргийн гурил	2700	2700	100.0
Хонины мах, кг	15000	16000	106.7
Үхрийн цул мах, кг	16000	18000	112.5
Элсэн чихэр, кг	3600	4900	136.1
Цагаан будаа, кг	3850	4000	103.9
Шингэн сүү, л	7000	7000	100.0
Бензин АН-92, л	2530	2530	100.0
Дизель түлш, л	3740	3640	97.3

Эх үүсвэр: ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

ХI.ХӨДӨӨ АЖ АХУЙ



Мал тооллогын дүнгээр 2023 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн нийт дүн 4072.2 мянга болж, 2022 оны нийт дүнгээс 9.5 хувь буюу 352.6 мянган толгойгоор өсчээ. Урьдчилсан дүнгээр адуун сүргийн тоо 177.3 мянга, үхэр 238.2 мянга, тэмээ 48.9 мянга, хонь 1218.4 мянга, ямаа 2389.3 мянган толгой болж өмнөх оныхоос адуу

16.9 мянга (10.6%), үхэр 15.2 мянга (6.8%), тэмээ 3.4 мянга (7.5%), хонь 110.4 мянга (10.0%), ямаа 206.6 мянган (9.5%) толгойгоор буюу таван төрөл дээр өссөн байна.

Нийт мал сүргийн дотор адуу 4.4 хувь, үхэр 5.8 хувь, тэмээ 1.2 хувь, хонь 29.9 хувь, ямаа 58.7 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос үхрийн эзлэх хувь 0.2 пунктээр буурч, адуу, хонины эзлэх хувь 0.1 пунктээр тус тус өсч, тэмээ, ямааны сүрэгт эзлэх хувьд өөрчлөлт ороогүй байна.

ХҮСНЭГТ 8

Малын төрөл	Малын тоо 2023 онд				мян.тол	
	Малын тоо		2023/2022		Нийт дүнд эзлэх хувь	
	2022	2023	Зөрүү	Хувь	2022	2023
Бүгд	3719.6	4072.2	352.6	109.5	100.0	100.0
Адуу	160.4	177.3	16.9	110.6	4.3	4.4
Үхэр	222.9	238.2	15.2	106.8	6.0	5.8
Тэмээ	45.5	48.9	3.4	107.5	1.2	1.2
Хонь	1108.1	1218.4	110.4	110.0	29.8	29.9
Ямаа	2182.7	2389.3	206.6	109.5	58.7	58.7

Аймгийн хэмжээнд 2024 оны 5 дугаар сарын мал төллөлт, төл бойжилтын мэдээгээр оны эхний хээлтэгчийн 48.6 хувь буюу нийт 838414 толгой хээлтэгч мал төллөсөн ба гарсан төлийн 91 хувь буюу нийт 761733 төл эсэн мэнд бойжиж байна. Бойжсон төлийг төрлөөр нь харвал ботго 5303, унага 12282, тугал 33642, хурга 254779, ишиг 455727 толгой тус тус бойжсон байна.

ХҮСНЭГТ 9. ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ, ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр, 5 сарын байдлаар

Баянхонгор аймаг						
Малын төрөл	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Төллөсөн хээлтэгч	838663	13013	35874	5344	288344	496088
Төллөсөн хээлтэгчийн эзлэх хувь	48.6	21.7	37.9	29.4	54.7	48.4
Бойжсон төл	761733	12282	33642	5303	254779	455727
Төл бойжилтын хувь	91.0	94.4	93.8	99.2	88.4	91.9

ХҮСНЭГТ 10. ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ, сумаар, малын төрлөөр

Сумын нэр	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Дүн	1724789	60043	94598	18176	526771	1025201
Баянхонгор	66641	3159	8292	109	24270	30811
Баацагаан	131247	2223	2183	1082	28474	97285
Баянбулаг	48398	2175	3181	6	25172	17864
Баянговь	91674	1141	577	1562	11722	76672
Баянлиг	92476	1016	549	6555	11632	72724
Баян-Овоо	88681	3161	2514	192	47169	35645
Баян-Өндөр	61919	535	256	2050	8207	50871
Баянцагаан	78039	1180	854	661	16614	58730
Богд	87843	1834	2661	1465	14714	67169
Бөмбөгөр	136963	4597	2499	99	40392	89376
Бууцагаан	114695	3228	3183	654	26699	80931
Галуут	118479	7804	16696	31	53246	40702
Гурванбулаг	67293	4257	6709	6	37007	19314
Жаргалант	57108	4926	13327	0	22035	16820
Жинст	76528	2067	1140	919	18543	53859
Заг	59184	3167	2967	60	26969	26021
Өлзийт	110336	4572	4817	121	40135	60691
Хүрээмарал	85168	3610	2307	170	34556	44525
Шинэжинст	77550	633	180	2428	9559	64750
Эрдэнэцогт	74567	4758	19706	6	29656	20441

ХҮСНЭГТ 11. ГАРСАН ТӨЛИЙН ТОО, сумаар, малын төрлөөр, 5 сарын байдлаар

№	Сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
		838663	13013	35874	5344	288344	496088
1	Баянхонгор	17974	206	789	12	7714	9253
2	Баацагаан	72563	520	790	425	17128	53700
3	Баянбулаг	27868	709	1651	2	14989	10517
4	Баянговь	72070	108	77	671	7986	63228
5	Баянлиг	16652	96	94	1023	4204	11235
6	Баян-Овоо	32184	562	741	71	20243	10567

7	Баян-Өндөр	37576	233	148	916	5749	30530
8	Баянцагаан	72948	721	551	290	15792	55594
9	Богд	42143	585	830	548	8893	31287
10	Бөмбөгөр	18504	50	82	3	8041	10328
11	Бууцагаан	77909	1022	987	177	22160	53563
12	Галуут	52900	700	2300	0	30400	19500
13	Гурванбулаг	28976	833	1531	0	19818	6794
14	Жаргалант	37716	2358	7381	0	15698	12279
15	Жинст	47658	804	760	390	12636	33068
16	Заг	22787	274	460	9	10434	11610
17	Өлзийт	52642	594	1152	8	25092	25796
18	Хүрээмарал	35710	559	868	9	15336	18938
19	Шинэжинст	17289	155	49	790	2762	13533
20	Эрдэнэцогт	54594	1924	14633	0	23269	14768

2024 оны 5 дугаар сарын том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 244819 толгой мал хорогдсон нь оны эхний малын 6.01 хувийг эзэлж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 264, адуу 9930, үхэр 31604, хонь 73214, ямаа 129807 толгой тус тус хорогджээ.

ХҮСНЭГТ 12. ОНЫ ЭХНИЙ МАЛЫН ТОО, СУМААР, МАЛЫН ТӨРЛӨӨР

Сумын нэр	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Дүн	4072203	177295	238203	48948	1218431	2389326
Баянхонгор	153948	9130	20831	318	55654	68015
Баацагаан	328599	7208	5830	3054	68016	244491
Баянбулаг	109513	6065	7936	15	53378	42119
Баянговь	205301	3166	1324	3862	26645	170304
Баянлиг	206938	2884	1357	17200	25453	160044
Баян-Овоо	233492	10197	7721	476	124371	90727
Баян-Өндөр	153691	1578	558	6016	20851	124688
Баянцагаан	180438	3505	2058	1670	37691	135514
Богд	212692	5682	6857	3874	34695	161584
Бөмбөгөр	314199	13644	6179	270	93331	200775
Бууцагаан	266080	9133	7676	1535	61198	186538
Галуут	275194	22447	39105	95	121347	92200
Гурванбулаг	152507	12747	16919	12	78867	43962
Жаргалант	126750	13812	31375	2	45097	36464
Жинст	181719	5588	2529	2139	43139	128324
Заг	128186	9118	7024	140	56149	55755
Өлзийт	276124	12825	12404	391	98998	151506
Хүрээмарал	203029	11196	6163	587	80699	104384
Шинэжинст	174531	2056	465	7266	22398	142346
Эрдэнэцогт	189272	15314	53892	26	70454	49586

ХҮСНЭГТ 13. ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумаар, малын төрлөөр, эхний 5 сарын байдлаар

№	Сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
		259762	10871	32843	378	79489	136181
1	Баянхонгор	7375	225	733	0	2642	3775
2	Баацагаан	12132	77	38	2	3104	8911
3	Баянбулаг	9112	607	1105	0	3509	3891
4	Баянговь	5699	75	45	37	340	5202
5	Баянлиг	11909	166	101	224	1185	10233
6	Баян-Овоо	20597	950	1177	0	9420	9050
7	Баян-Өндөр	1281	1	2	1	151	1126
8	Баянцагаан	546	0	9	0	45	492
9	Богд	5939	59	64	9	566	5241
10	Бөмбөгөр	27356	676	277	0	8139	18264
11	Бууцагаан	21087	650	545	37	4584	15271
12	Галуут	34989	3138	7994	0	12399	11458
13	Гурванбулаг	27511	986	8847	0	9577	8101
14	Жаргалант	11714	847	5638	0	2875	2354
15	Жинст	9941	137	95	63	2990	6656
16	Заг	6619	533	1224	0	2043	2819
17	Өлзийт	13515	209	362	2	5060	7882
18	Хүрээмарал	18127	974	567	0	6522	10064
19	Шинэжинст	2179	5	0	3	99	2072
20	Эрдэнэцогт	12134	556	4020	0	4239	3319

ХҮСНЭГТ 14. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, малын төрлөөр, 5 сарын байдлаар

Баянхонгор аймаг

Малын төрөл	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өвчнөөр хорогдсон	487	0	2	0	134	351
<i>Өвчнөөр хорогдсон малын эзлэх хувь</i>	0.19	0	0.01	0	0.17	0.26
<i>Хорогдсон хээлтэгчийн эзлэх хувь</i>	25.41	21.57	25.41	10.15	28.88	23.73
<i>Хорогдсон малын эзлэх хувь</i>	6.38	6.13	13.79	10.77	6.52	5.7

Эх үүсвэр: ҮСХ, Хөдөө аж ахуйн мэдээ

ХИИ.АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2024 оны 5 дугаар сард өссөн дүнгээр 4,202.9 сая төгрөгт хүрчээ. Өмнөх оны мөн үеэс 961.4 сая төгрөг буюу 18.6 хувиар буурсан байна. Нийт үйлдвэрлэлтийг салбараар авч үзвэл: Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 3,232.8 сая төгрөг буюу 76.9 хувь, боловсруулах аж үйлдвэр 157.6 сая төгрөг буюу 3.7 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалт үйлдвэрлэл 650.3 сая төгрөг буюу 15.5 хувь, ус хуримтлуулах, ариутгах, түгээх, үйл ажиллагаа 27.3 сая төгрөг буюу 0.6 хувь, хог хаягдлыг

цуглуулах, зайлуулах үйлчилгээ 134.9 сая төгрөг буюу 3.2 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ-10 Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн борлуулалт

Үзүүлэлт	2023 V	2024 IV	2024 V	2024 III 2024 IV
Нийт дүн	5,164,325.40	5,281,376.40	4,202,896.50	80
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	4,128,547.20	3,361,658.20	3,232,806.70	96.2
Чулуун нүүрс олборлолт	95,000.00	150,000.00	92,000.00	61.3
Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт	4,033,547.20	3,211,658.20	3,140,806.70	97.8
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	200,263.60	146,250.00	157,591.00	107.7
Мах боловсруулах, консервлох	15,750.00	20,200.00	22,300.00	110.4
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	12,800.00	13,000.00	9,800.00	75.4
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	171,713.60	86,350.00	91,021.00	105.4
Бусад даавуун эдлэл үйлдвэрлэл	0	1,200.00	1,800.00	150
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	0	0	3,120.00	0
ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	691,862.70	1,358,109.40	650,340.20	47.9
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	93,831.10	262,621.00	27,291.70	10.4
Хог хаягдлыг цуглуулах	49,820.80	152,737.80	134,866.90	88.3

Мэдээлэл авах холбоосууд: <http://www.bayankhongor.nso.mn/>
<http://www.1212.mn/> Утас: 70442081: 70442403

